



**НИЙСЛЭЛИЙН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/46

Улаанбаатар хот

**Засаг даргын Тамгын газрын Дотоод журамд
нэмэлт оруулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, Хөдөлмөрийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 130 дугаар зүйлийн 130.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Хан-Уул Засаг даргын Тамгын газрын даргын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн А/65 дугаар тушаалаар батлагдсан “Засаг даргын Тамгын газрын Дотоод журам”-ын 7 дахь заалтад дараах агуулгатай 7.18 гэсэн дэд заалт нэмсүгэй.

“7.18. Албан хаагч өөрөө эсвэл түүний эхнэр, нөхөр, төрсөн хүүхэд нь хүнд өвчний улмаас магадлан итгэмжлэгдсэн эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр дотоод, гадаадын эмнэлгийн байгууллагад зайлшгүй эмчлүүлэх шаардлагатай тохиолдолд холбогдох баримтыг үндэслэн эмчилгээний зардлын тодорхой хувийг олгож болох бөгөөд дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2021 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан журамд заасан ажилтанд тавигдах шалгуур, дэмжлэг олгох мөнгөн дүнг баримтална”.

2. Энэ тушаалыг батлагдсан өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



С.ЭНХБАЯР

1170200459